

МУИС-ийн түүхийн сургалтын өөрчлөлт шинэчлэл:

Үндэстний түүхээс дэлхийн түүх тийш*

МУИС, Түүхийн тэнхимийн багш, доктор Б.Чинзориг

- Оршил
- Дэлхийн түүхийн үүсэл хөгжил ба евроцентризмыг даван туулахуй
- Дэлхийн түүх ба үндэстний үзлийг даван туулахуй
- Дэлхийн түүх ба иргэний даяарших чадварыг төлөвшүүлэхүй
- Сурах бичгийн шинэчлэл ба глобал перспективээр харах үзэл баримтлал
- Дүгнэлт

Оршил

1990-ээд оны турш, 2000-аад оны эхээр дэлхийн хөгжингүй улс орнуудад дээд боловсролын шинэчлэл явагдсан. Түүнтэй зэрэгцэн уг шинэчлэл пост-социалист орнууд болон эдийн засгийн интеграцид харьцангуй түргэн хугацаанд орж хөгжсөн Азийн орнуудад ч гэсэн явагдсан юм. Харин Монгол зэрэг хөгжиж буй улс орнууд дээд боловсролын шинэчлэлийг 2000-аад оны дунд/сүүл үеэс хэд хэдэн үе шаттайгаар хэрэгжүүлэв. МУИС-ийн хувьд сургалтын шинэчлэлийг 2011 оны сүүлээс аажмаар¹, 2014 оноос эхлэн бодитой бөгөөд эрчимтэй хэрэгжүүлсэн.

Монгол улсад явагдаж буй дээд боловсролын салбарын энэ өөрчлөлт, шинэчлэл нь үндсэндээ *төвийн үйлдвэржсэн орнууд*² буюу барууны стандарттай улс орнуудын дээд боловсролын стандартыг олон улсын, үүнд *хагас-захын* улс орнууд³ болон *захын* улс орнуудын⁴ дээд боловсролд нэвтрүүлэх, улмаар глобальчлагдаж буй эрин үеийн хэрэгцээ шаардлагын дор дэлхийд барууны нэгдсэн боловсролын стандартыг бий болгох гэсэн үйл явцийн нэг хэсэг байв.⁵ Өөрөөр хэлбэл, эдүгээ манай улсын засгаас газраас хэрэгжүүлэхээр зорьж буй дээд боловсролын бодлого, их дээд сургуулиудын тогтолцооны шинэчлэл нь үндэсний дээд боловсролын тогтолцоог “дэлхийн зэрэглэл бүхий” Америк, Англи тэргүүтэй “барууны” жишигт нийцүүлэн өөрчлөх гэсэн үйл явц юм. Энэ үйл явцын хүрээнд засгийн газраас хамгийн сүүлийн байдлаар 2018 оноос эхлэн их, дээд сургуулиудыг “судалгааны байгууллага” болгон өөрчлөх зорилго албан ёсоор тавиад байна.

* Энэ өгүүлэл *Эх түүхийн хичээл, шинэ хандлага: Үндэсний семинар*. Улаанбаатар: Адмон, 2019, 52-68-д хэвлэгдсэн болно.

¹ Дэлгэржаргал, П. “Дээд боловсролын шинэтгэл ба мэргэжлийн түвшний түүхийн сургалтын тулгамсан асуудлууд”. *Эх түүхийн сургалт, боловсролын уламжлал, шинэчлэлийн асуудлууд (Илтгэлийн эмхэтгэл)*. Улаанбаатар: Адмон, 2012, 19-20.

² Core Industrialized Nations буюу АНУ, Британийн Вант улс, Баруун Европ, Австрали зэрэг тэргүүлэх зэргийн хөгжингүй улс орнууд.

³ Semi-periphery Nations буюу Хятад, Орос, Энэтхэг, Зүүн Европын улс орнууд.

⁴ Periphery Nations буюу Дундад Азийн постсоциалист орнууд, Монгол, Африк, Латин Америкийн зарим улс орнууд.

⁵ Чинзориг, Б. “МУИС-ийн түүхийн сурах бичиг бичсэн туршлагаас”. *Түүхийн сургалтын шинэчлэл: Явц, үр дүн, тулгамдсан асуудал*. Улаанбаатар: Удам соёл, 2017, газрын зураг 1, 69-70.

2014 онд явагдсан МУИС-ийн сургалтын шинэчлэлийн хүрээнд Түүхийн тэнхим сургалт, хичээлийн хөтөлбөрөө шинэчлэн боловсруулахдаа олон улсын их сургуулиудын зэрэглэлд (Shanghai Ranking ба Times Higher Education) олон улс, бүс нутаг, улс орны хэмжээнд тэргүүлж буй их сургуулиудын сургалтын хөтөлбөрүүдийг судалж, тэдгээрт тусгагдсан нийтлэг болон онцлог үзэл санаа, мөн чанарыг тодорхойлсны дараа өөрсдийн уламжлалт сургалтын хөтөлбөртэй харьцуулан жиших замаар өнөөгийн Монголын түүхийн сургалтанд тулгарч буй бэрхшээл, сул талуудыг илрүүлэхийн зэрэгцээ хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, үзэл баримтлал, бодлого, үйл ажиллагаагаа уялдуулан өөрчлөхийг хичээсэн. Миний бодлоор, энэ үед бидний хийсэн хамгийн чухал дүгнэлт бол CIN-ийн их сургуулиудын түүхийн тэнхимүүдийн сургалт, судалгааны зорилго нь *дэлхийн түүх суурьтай* мэргэжилтэн бэлтгэхэд чиглэж байхад манай улсын түүхийн сургалт *үндэсний түүх суурьтай* мэргэжилтэн бэлтгэн төгсгөхөд чиглэж байдаг юм байна гэсэн дүгнэлт байв. Хэрвээ Монгол улсын их, дээд сургуулийн сургалтын эцсийн зорилго CIN-ийн дээд боловсролын стандарттай ямар нэг хэмжээгээр ижилсэх явдал юм бол энэ нь Монгол улсын их дээд сургуулиудын түүхийн сургалт олгодог тэнхимүүд сургалт, судалгаандаа “олон улсын хэмжээсүүдийг” нэвтрүүлж, сургалтын хөтөлбөрөө ирээдүйд дэлхийн түүх суурьтай болгон өөрчлөх хэрэгцээ хүссэн хүсээгүй тулгарна гэсэн үг юм. Ийм нөхцөлд төгсөгчдөө зөвхөн үндэсний түүх төдийгүй, мөн бүс нутаг, олон улс, цаашилбал глобаль хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн болгон бэлтгэхэд түүхийн боловсрол олгож буй нийт их, дээд сургуулийн тэнхимүүд сургалтын хөтөлбөрөө чиглүүлэх шаардлагатай болно.

Гэтэл манай их, дээд сургуулиуд улам ихээр даяаршиж буй өнөө цаг үеийн ийм шаардлагад нийцсэн ирээдүйн түүхч боловсон хүчинг хэр зэрэг бэлтгэн гаргаж байна вэ? Монголын үндэсний түүхийн сургалт, олон улсын их дээд сургуулиудын түүхийн сургалтын хооронд яг ямар зөрүү оршиж байгаа юм бэ? Зэрэглэл өндөр олон улсын их дээд сургуулиудын түүхийн сургалт хэрхэн явагддаг юм вэ? Тэдний сургалтууд өөр хоорондоо юугаараа ялгагдаж байна вэ? Тэдгээрийн давуу болон дэвшилтэй зүйл нь юу вэ? Одоо хаашаа, ямар байдалтай өөрчлөгдөн хувирч байна вэ? Ирээдүйд хэрхэн өөрчлөгдөн шинэчлэгдэх ёстой вэ? Эдгээр асуултуудад хариулт өгөхөөр хэлэлцэн бичсэн зүйл одоогоор тун хомс байна. Тиймээс эдгээр асуудлуудыг ямар нэг хэмжээгээр тодруулах үүднээс энэ илтгэлийг бэлдлээ.

1. Дэлхийн түүхийн үүсэл хөгжил ба евроцентризмыг даван туулахуй

Түүх сөхвөл, CIN-ийг тодорхойлж буй АНУ-ын их, дээд сургуулиудын түүхийн тэнхимүүд 1960-аад оныг хүртэл сургалт, судалгаагаа үндэсний баримжаатай боловсруулж, жишээ нь бакалаврын сургалтын хөтөлбөрийнхөө ерөнхий суурийн хичээлүүдэд Америк, Өрнөдийн иргэншлийн түүх, мэргэжлийн хичээлүүдэд АНУ, Британи, Европын түүхийг судлах хичээлүүдийг багтааж байсан ажээ. Энэ үед АНУ-ын их сургуулиудын түүхийн тэнхимийн багш нар бараг бүгд европчууд байсан ба тэдний дийлэнх нь Европ, Умард Америкийн түүхээр мэргэжиж, цөөхөн хэдхэн нь Алс Дорнодын буюу Зүүн Азийн түүх заадаг, харин Зүүн-Өмнөд Ази, Дундад Дорнод, Африкийн иргэншлүүдийн түүхийн курс хичээлийн тоо тун бага байв.⁶ Тухайн үед тэнхимүүдийн хэмжээ, нөөц бололцоо болон Хүйтэн дайны нөхцөл байдлаас шалтгаалан Азийн түүх (АНУ-ын улс төрийн хамааралтай дайн, хямралууд, жишээ нь Солонгосын хямралыг судлахад чиглэсэн), Оросын түүх (Хүйтэн дайн, социалист орнуудыг судлахад чиглэсэн), Латин Америкийн түүхийг (энэ бүс нутаг дахь АНУ-ийн эрх ашгийг судлахад чиглэсэн) тун хязгаарлагдмал цар хүрээнд судлахад чиглэж,

⁶ Andrea, Alfred J. “On the Teaching of Global History.” *Historian* 53/1, 1990, 145.

цөөн тохиолдолд тухайн тэнхимийн удирдлагын сонирхлоор дэлхийн ямар нэг бүс нутгийн талаарх хичээлүүдийг санал болгож байв. Гэвч АНУ-ын дэлхийд эзэлж байсан глобаль байр суурь тэлсэн явдал, Форд, Рокфеллерын гэх мэт санхүүгийн тэтгэлэг, засгийн газрын дэмжлэгтэй судалгааны сонирхол, олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ зэрэг олон хүчин зүйлсээс хамааран энэ байдал нь өөрчлөгдөж, *үндэсний түүх (national history)* суурьтай сургалтаас улам бүр *бүс нутаг (regional history)*, эсвэл *хил залгаа хэдэн хэдэн бүс нутаг хоорондын (transregional history)*, бүр цаашилбал *дэлхийн түүх (world history)* судлах, сургалт явуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэх болсон байна.⁷

АНУ-д энэ үед ихээхэн давамгайлж байсан *үндэсний түүх суурьтай* сургалтаас *дэлхийн түүх суурьтай* сургалт руу шилжсэн шилжилт зөвхөн тухайн үеийн Хүйтэн дайнтай холбогдсон улс төрийн нөхцөл байдлаас ч шалтгаалж байсан биш, мөн түүхийн шинжлэх ухааны өмнө тулгамдаж байсан бэрхшээлийг даван туулах боломж олгож байснаас шалтгаалан явагдсан байна. Өөрөөр хэлбэл, америкийн түүхчид сургалтын шинэчлэлээр дамжуулан өөрсдийнх нь буюу Америк, Европын түүхийн судалгаанд түгээмэл тохиолдож байсан евроцентрист үзлийг багасгах боломжтой гэж үзжээ. Үнэхээр ч дэлхий даяар Европ, Америкийн империализм, колоничлол ноёрхож, үндэстний үзэл, үндэстэн-улсууд буй болсон эрин үед буюу XIX зууны эхэн үеэс Дэлхийн II дайныг дуустал шинжлэх ухаан болон хөгжихөд нь түүх судлалд евроцентризм нэн чухал байр суурь эзэлсээр ирсэн билээ. Евроцентрист үзэл ёсоор, түүх судлалын үндсэн судлагдахуун нь Европын төр улсууд болж, харин төргүй улс орнуудыг “нийгэм” юм уу “соёл”-ын судлагдахуун учраас түүхийн шинжлэх ухаан бус, антропологи судлах ёстой гэж үзэж байв. Өөрөөр хэлбэл, тухайн үед дэлхийд ноёлж байсан европчууд л “өөрчлөгдөн хувирах” түүхтэй, харин бусад нь “үл өөрчлөгдөх” ёс заншилтай тул зэрлэг бүдүүлэг, эгэл дорой, эртний хэв маягтай болж байлаа. Ийм үзэл давамгайлсан үед дэлхий дахины түүхийг глобаль хэмжээсээр авч үзэх боломжгүй, гагцхүү “дэлхийн түүх” гэсэн ойлголтод дан ганц Өрнөд Европын иргэншлийн дэлхий дахинд тархан дэлгэрсэн, нөлөөлсөн түүхийг ойлгож байв.

Гэтэл Дэлхийн II дайны дараа Европ дахь Франц, Англи, Герман зэрэг улс орнуудад хөгжиж байсан иргэншлийн түүхийн судалгааны нөлөөгөөр АНУ-д “дэлхийн түүх” гэсэн шинэ судалгааны сэдэв үүсч, улмаар энэ сэдэв нь ертөнцийн төвд Европ, Америкийг тавьж ойлгодог үзлийг халах “дэлхийн түүх судлалын хөдөлгөөн” болон хувирчээ.⁸ Дайны дараа АНУ дэлхийг тодорхойлогч их гүрэн болон хувирч, Хүйтэн дайны “гол тоглогч”-ийн хувиар дэлхийн олон улс орны түүх, соёл, улс төрийг танин мэдэх хэрэгцээ шаардлага ихэссэнээр уг хөдөлгөөн улам эрчимжсэн ажээ. “Дэлхийн түүх” хэмээх ойлголтыг өнөөгийн утгаар анх хэрэглэх болсон эрдэмтдийн нэг Чикагогийн их сургуулийн Уиллиам Макнилл (William H. McNeill, 1917-2016) уг ухагдахууныг Освальд Шпенглер, Арнольд Тойнби нарын судалгааны аргазүйд тулгуурлан тодорхойлохдоо тэдгээрээс ялгаатай нь дэлхийд “өөр хоорондоо ангид үүсэн хөгжсөн иргэншлүүдийн түүх” юм уу эсвэл “ямар нэг давуу иргэншил бусад иргэншлүүдээс товойн ялгарч дэлхийд тархсан түүх” бус, харин адил байр суурьтай “янз бүрийн иргэншлүүдийн хооронд явагдаж байсан харилцаа холбоо (*inter-civilizational contacts*)”, “иргэншил дамнан явагдсан харилцан үйлдэл, солилцоонууд (*trans-*

⁷ Brooks, George E. “An Undergraduate World History Curriculum for the Twenty-First Century.” *Journal of World History* 2/1, 1990, 65-66.

⁸ Allardyce, Gilbert. “Toward World History: American Historians and the Coming of the World History Course.” *Journal of World History* 1/1, 1990, 40-45. Энэ өгүүлээс дэлхийн түүхийн сургалт АНУ-д хэрхэн хөгжсөн талаар дэлгэрэнгүй авч үзсэн.

civilizational interactions and exchange)”-ын судлал гэж тайлбарлаж байв.⁹ Ингэхдээ тэр бээр иргэншлүүдийг хооронд нь холбож байсан хүчин зүйлс, солилцоонуудаас алсын зайн худалдаа, цэрэг дайн зэрэг нийгмийн үзэгдлүүд, тахал, халдварт өвчин зэрэг байгаль, экологийн үзэгдлүүдийн түүхийг судлахад гол анхаарлаа хандуулж байв.

Евроцентризмээс зайлсхийх гэсэн оролдлогыг АНУ-д энэ үед мөн хэд хэдэн эрдэмтэд хийхийг эрмэлзэж байв. Францийн Анналийн дэг сургуулийг үндэслэгч Фернан Бродель (Fernand Braudel, 1902-1995) худалдаа, соёлын хүчин зүйлээр тодорхойлогдсон “дэлхийн систем” болгон судалж байсныг хожим түүний шавь Имманиуэл Валлерстайн (Immanuel Wallerstein, 1930-) хөгжүүлэхдээ хүн төрөлхтний түүхийн аль ч үед эдийн засгийн тогтолцоо нь нийгмийн тодорхойлох үүрэг гүйцэтгэж ирсэн болохыг онцлон, дэлхийн иргэншил бүрт өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий худалдааны тогтолцоо оршин тогтнож байсан гэж үзэж байв. Түүний судалгааны гол сэдэв нь Шинэ үед дэлхийд ноёрхсон Өрнөд Европын эдийн засгийн тогтолцоог судлахад чиглэж байсан ч “эдийн засгийн тогтолцоо” гэсэн хэмжээсээр дэлхийн түүхийг хэрхэн задлан шинжилж болдогын жишээг нотлон харуулснаараа ихээхэн ач холбогдолтой байсан.¹⁰ Тиймээс түүний судалгааны аргагүй дэлхийн түүхийг евроцентрист үзлээс ангид судлах гэсэн америкийн түүх судлалд ихээхэн нөлөөлсөн байдаг. Түүний нэг тод жишээ нь Жанет Абу-Лугодын (Janet Abu-Lughod, 1928-2013) *Before European Hegemony: The World System A.D. 1250-1350* хэмээх бүтээл байсан юм.¹¹ 1989 онд хэвлэгдсэн уг бүтээлд Валлерстайны авч үзсэн Шинэ үеэс өмнөх үе буюу Дундад зууны сүүлийн дэлхийн эдийн засгийн тогтолцоог задлан шинжлэхэд зориулагдсан бөгөөд энэ үед ямар нэг бие даасан бүс нутаг дэлхийн эдийн засагт ноёрхлоо тогтоож байсан бус, харин өөр хоорондоо харилцан холбоотой хэд хэдэн бүс нутгуудын эдийн засгийн нарийн түвэгтэй харилцаа нь тухайн үеийн дэлхийн эдийн засгийн тогтолцоог тодорхойлж байсан гэж дүгнэсэн байна.¹²

Хүйтэн дайн төгсөхөд АНУ-д “дэлхийн түүх” гэсэн түүхийн бие даасан судалгааны чиглэл үүссэн байсан бөгөөд энэ нь адил сэдэв, чиглэлээр судалгаа явуулж байсан дэлхийн олон улсын судалгаанаас хавьгүй давуу хөгжсөн байв. Энэ үед “дэлхийн түүх” (*world history*) гэх нэр томъёог “дэлхий дахины бүхий л түүхэн өнгөрсөн цаг үе” гэж ойлгохоо аль хэдийнэ больсон байжээ. Дэлхийн түүх судлалаар дагнасан *Journal of World History*-ын сэтгүүлийн анхны дугаар 1990 онд хэвлэгдэхэд эрхлэн хэвлэгчид нь уг ухагдахууныг “дэлхийн түүхийн авч үзэх үндсэн асуудал бол том хэмжээний түүхэн үйл явцад оролцож буй хүмүүсийн хооронд явагдаж байсан харилцан үйлдлүүд” хэмээн тайлбарлаж байлаа.¹³

АНУ-д Хүйтэн дайны үед буй болсон дэлхийн түүхийн судлалын хөгжилтэй зэрэгцээд дэлхийн түүх судлах оюутнуудын эрэлт хэрэгцээ ч ихсэж их дээд сургуулиуд үндэстний түүх суурьтай сургалтаас дэлхийн түүх суурьтай сургалтанд аажим аажмаар шилжин орсон байна. Сургалтын энэ өөрчлөлтөд мөн л сургалтын хөтөлбөрүүдэд оршиж байсан евроцентрист агуулгыг

⁹ McNeill, William H. “The Changing Shape of World History.” *History and Theory* 34/2, 1995, 13-15; Allardyce, Gilbert. “Toward World History: American Historians and the Coming of the World History Course.” *Journal of World History* 1/1, 1990, 62-76. Дэлхийн түүх судлалаар түүний туурвисан хамгийн анхны чухал бүтээл бол 1963 онд хэвлэгдсэн *The Rise of the West: A History of the Human Community* юм.

¹⁰ Түүний гурван боть зохиолоос хамгийн чухал нь хоёрдугаар боть болно: Immanuel Wallerstein. *The Modern World System II: Mercantilism and the Consolidation of the European World Economy, 1600-1750*-ийг үзнэ үү.

¹¹ Mazlish, Bruce. “Comparing Global History to World History.” *Journal of Interdisciplinary History* 28/3, 1998, 386-387.

¹² Abu-Lughod, Janet L. *Before European Hegemony: The World System A.D. 1250-1350*. New York and Oxford: Oxford University Press, 1989, 352-364.

¹³ Bentley, Jerry H. “A New Forum for Global History.” *Journal of World History* 1/1, 1990, iii-v.

халах оролдлогоос үүдэлтэй байсан ажээ. 1945-1960-аад онуудад хөгжсөн дэлхийн түүх судлалын үр дүнд 1970-аад оны үед дэлхийн түүхээр мэргэжүүлэн сургах хөтөлбөрүүд олширч, улмаар уламжлалт үндэсний баримжаатай хичээлийн оронд дэлхийн аль нэг бүс нутаг, улс орны түүхээр курс хичээл санал болгох чадвартай нарийн мэргэжсэн боловсон хүчин төрөн гарчээ. 1980-аад оны сүүл, 1990-ээд оны үед америкийн олон тэнхимүүдэд Өрнөдийн иргэншлийн хичээлүүд бараг орохоо байж түүхийн суурь хичээлүүдийн уламжлалт сэдэв, агуулга тэнхим, суралцагчийн аль аль сонирхлоос гарч, оронд нь дэлхийн түүхийн хичээлүүд нэмэгдэж, үндэсний сургалт, судалгааг газарзүй, цаг хугацаа, сэдэв агуулгын хувьд өргөтгөн тэлэх, гүнзгийрүүлэх, дэлхийн бусад бүс нутаг, улс орнуудтай харьцуулан судлах хандлагатай болсон байв.¹⁴ Зөвхөн судалгааны ч биш, мөн сургалтын байгууллагын дэлхийн түүх сонирхон судлагч нарыг нэгтгэсэн байгууллагууд ч 1980-аад оны үед байгуулагджээ. Эдгээрээс хамгийн том нь 1982 онд байгуулагдсан Дэлхийн түүх судлалын холбоо (World History Association) байв. Энэ холбоо нь их сургуулийн профессор, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгч, магистрант докторант, бие даасан судлаачдыг хамарч, үйл ажиллагаагаа зөвхөн АНУ төдийгүй дэлхийн олон улсуудад явуулж дэлхийн түүхийн хичээлийн үндэсний шинж чанартай хөтөлбөр, стандарт боловсруулах, эрдмийн хэлэлцүүлэг зохион байгуулах, эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах, судалгааны төв салбарлан байгуулах болжээ.

1990-ээд он гэхэд АНУ-ын дөрвөн жилийн сургалттай бакалаврын боловсрол олгодог их дээд сургуулиудын 24 хувь нь (844 их, дээд сургууль) дэлхийн/глобаль түүхээр дагнасан курс хичээл санал болгож, түүнд америкийн нийт оюутны 3 гаруй хувь нь (330000 оюутан) судалдаг болсон байв. Мөн энэ үед АНУ-ын түүхийн тэнхимүүдийн боловсон хүчний дийлэнх нь Африк, Ази, Дундад Дорнод болон Латин Америкийн түүх судлалаар мэргэжсэн, тэдний дотор европ-бус гаралтай багш нарын хувь ч харьцангуй ихэссэн ажээ.¹⁵ Магистрын зэргээ Африк, Ази, Европ, Латин Америкийн ямар нэг бүс нутаг, улс орны тухайлсан сэдвийн түүхээр бичиж хамгаалсны дараа тухайн сэдвээ дэлхийн бусад бүс нутагтай харьцуулсан судалгаа болгон өргөтгөх замаар дэлхийн түүхээр докторын зэрэг хамгаалдаг өнөөгийн америкийн их сургуулийн жишиг энэ үед бий болжээ.¹⁶

Дэлхийн түүх судлал, дээд боловсролын сургалтанд гарсан дээрх өөрчлөлт ч гэсэн АНУ-ын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгалаа олж байжээ. Анх XIX зуунд америкийн их сургуулиудын адилаар дунд сургуулиудад “ерөнхий түүх” (general history) гэсэн хичээлийн дор түүхийг Адам, Евагаар эхлүүлэн эртний грек-ромын сонгодог үеийн түүх, дундад зууны үеийн Английн түүхээр төлөөлүүлэн зааж байв. Дараа нь, 1920-иод оноос Дэлхийн II дайныг дуустал сургалтын хөтөлбөрт шинээр орж ирсэн “Шинэ үеийн түүх” хичээлээр Европын шинэ үеийн түүхийг заадаг болсон байна. Харин дайны дараа энэ байдал эрс өөрчлөгдөж сургалтыг дэлхийн өөр бусад бүс нутгууд, иргэншлүүдийн хоорондын харилцаа, нийтлэг талуудыг онцлон тусгасан дэлхийн түүхийн агуулгатай болгох давалгаан бий болж, 1960-аад оноос эхлэн хичээлийн тусгай хөтөлбөрүүд янз бүрээр зохиогдох болов. Гэвч энэ үед АНУ-ын бүх мужуудад дэлхийн түүх заагдаж байгаагүй бөгөөд дэлхийн түүхийн агуулгатай хичээлүүдэд европын түүх давамгайлсан

¹⁴ Brooks, George E. “An Undergraduate World History Curriculum for the Twenty-First Century”. *Journal of World History* 2/1, 1990, 65-67.

¹⁵ Andrea, Alfred J. “On the Teaching of Global History.” *Historian* 53/1, 1990, 145.

¹⁶ 2014 оны байдлаар энэ холбоонд АНУ-ын дэлхийн түүхээр магистр, докторын сургалтын хөтөлбөртэй 116 их дээд сургууль хамрагдаж байв. Холбооны тусламжтайгаар 2008 онд Германы Дрезден хотод Глобаль болон Дэлхийн түүх судлах байгууллагуудын сүлжээ (Network of Global and World History Organizations), 2010 онд Италийн Колдижиоко хотод Олон улсын их түүх судлалын холбоо (International Big History Association) байгуулагдсан.

хэвээр байсан ажээ. Хүйтэн дайны дараа 1990-ээд оноос эхлэн америкийн ихэнх мужуудын дунд болон ахлах сургуулиудын хичээлийн хөтөлбөрт дэлхийн түүх багтаж, улмаар үндэсний хэмжээнд ялангуяа ахлах сургуулийн хичээлийн хөтөлбөрт заавал байх ёстой чухал элемент болсон тул Үндэсний Үнэлгээг Удирдах Зөвлөлөөс (National Assessment Governing Board) зохион байгуулдаг Боловсролын Түвшин Тогтоох Үндэсний Үнэлгээгээр (National Assessment of Educational Progress) сурагчдын дэлхийн түүхийн боловсролыг шалган үнэлэх зорилготой стандарт (AP World History Standard) боловсруулан түүгээр 2002 оноос эхлэн шалгалт авдаг болсон байна.¹⁷ 2014 оны америкийн ахлах сургуулиудад заадаг дэлхийн түүхийн сурах бичгүүдийн харьцуулсан судалгаагаар хэдийгээр АНУ-д Европоос бусад бүс нутгийн судалгаа үлэмж хөгжсөн ч европ төвт үзэл бүрэн арилаагүй хэвээр байгаа гэж дүгнэсэн байна.¹⁸

1990-ээд он, 2000 он гарснаар АНУ болон дэлхийн тэргүүлэх сургуулиудад дэлхийн түүх судлал улам бүр хөгжсөөр түүнээс салбарлан “глобаль түүх” судлал салбарлан хөгжжээ. “Глобаль түүх” (*global history*) гэдэг нь глобальчлалын түүх судлал гэсэн үг юм. Тиймээс энэ нь орчин үеийн, одоо явагдаж буй үйл явцийн түүх юм. Глобаль түүх судлалын гол асуудал нь даяаршлын үүсэл гарлаас эхлэн орчин үеийн дэлхий даяар, нэг бүс нутгаас нөгөөд дамжин явагдаж буй улс төр, цэрэг дайн, хүрээлэн буй орчны асуудлууд, мөн олон улсын үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаа, хэрэглээний үзэл, хүний эрх, соёлын олон талт байдал, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн түүхийг судалж байна.¹⁹ Глобаль түүх судлалын анхны сэтгүүлийн 2006 онд гарсан эхний дугаарт британийн эрдэмтдийн тодорхойлсноор даяаршлын үйл явцийг мөшгин шинжилдгээрээ глобаль түүх дэлхийн түүхээс ялгагдаж байгаа юм. Түүнчлэн глобаль түүх нь дэлхийн түүхээс ялгаатай нь янз бүрийн нийгэм хооронд явагдаж буй асуудлуудыг авч үздэг учраас аргагүйн хувьд уламжлалт түүх судлалд оршдог түүхийг ямар нэг үндэстэн, үндэстэн улсын түүхийн үүднээс харж ойлгох явдлаас ангид байдгаараа, мөн олон шинжлэх ухааны уулзвар огтлолцол дээр тайлбар өгдөгөөрөө хамгийн чухал ач холбогдол, онцлогтой шинээр бий болж буй судлагааны салбар ажээ.²⁰

Хэрвээ бид дэлхийн зэрэглэлд тэргүүлж байгаа их сургуулиудын түүхийн тэнхимүүдийн санал болгож буй сургалтын хөтөлбөрийг ажиглавал эдүгээ АНУ-ын дэлхийн түүх суурьтай сургалтын хэв маягийг хэдийнэ хэрэгжүүлсэн болохыг түвэггүй мэдэж болно. Ингэснээр тэдгээр улс орнуудын их сургуулиудын түүхийн сургалт өмнө нь дан ганц үндэсний хэмжээнд түүх судлах чадвартай, түүхийг зөвхөн үндэсний түүхийн перспективээр харж судалдаг - үндэсний түүх суурьтай боловсон хүчин бэлтгэж байсан бэрхшээлээсээ гарч түүхийг глобаль перспективээр харж судалгаа хийх чадвартай, тэр хэмжээгээр олон олон улсад үнэлэгдэх, өрсөлдөх боломжтой боловсон хүчнүүдийг бэлтгэн гаргадаг болсон байна. Өөрөөр хэлбэл, хагас захын болон захын олон улсын их сургуулиудын түүхийн сургалтын өмнө тулгарч байсан бэрхшээлийг даван туулах боломжийг дэлхийн түүх суурьтай сургалт олгосон байна.

¹⁷ Bain, Robert B. and Shreiner, Tamara L. “Issues and Options in Creating a National Assessment in World History.” *The History Teacher* 38/2, 2005, 241-244. Энэ судалгаанд америкийн зарим мужийн ерөнхий боловсролын хөтөлбөрт багтсан дэлхийн түүхийн хичээлийн агуулгаас евроцентризм арилаагүй байгааг онцлон тэмдэглэжээ.

¹⁸ Bolgatz, Jane and Marino, Michael. “Incorporating More of the World into World History Textbooks: A Review of High School World History Texts.” *World History Connected* 11/2, 2014. <http://worldhistoryconnected.press.uillinois.edu/11.2/bolgatz.html> (хамгийн сүүлд 2019 оны I сарын 16).

¹⁹ Mazlish, Bruce. “Comparing Global History to World History.” *Journal of Interdisciplinary History* 28/3, 1998, 389-390.

²⁰ Clarence-Smith, William Gervase et al. “Editorial.” *Journal of Global History* 1, 2006, 1-2.

Гэхдээ америк болон европчуудын хувьд дэлхийн түүх судлал нь өөрсдийнх нь “үндэстний” үзэл болох европ төвт үзлийг ямар нэг хэмжээгээр даван туулах боломжийг олгож байсан шиг Европоос бусад улсуудад түүхэнд дан гагц үндэстний үзлийн үүднээс хандах хандлагыг ямар нэг хэмжээгээр даван туулах боломжийг олгож буй боловч зарим улс орнуудын хувьд энэ нь харилцан адилгүй агуулгатай байгааг анхаарууштай. Жишээ нь, хятад болон америкийн соёлын нөлөөг хүртсэн Өмнөд Солонгосын дэлхийн түүхийн сурах бичгүүдэд европ төвт үзэл агуулагдсаар байгаа, гэхдээ үүний хажуугаар мөн хятад төвт үзэл ч хүчтэй ажиглагддаг, энэ нь Европ, Хятад гэсэн хоёр соёлын хэмжээс дэлхий дахинд түгэн дэлгэрсэн байдлаар дэлхийн түүхийг ойлгуулах гэсэн зорилготой холбоотой байдаг ажээ.²¹

БНХАУ-ын хувьд, ЗХУ-тай харьцаа муудсан, Дэн Сяопингийн шинэчлэл, АНУ зэрэг барууны улстай дипломат харилцаагаа хөгжүүлсэн, мөн Тайван, Хонгконг, Сингапурын хөгжил зэрэг улс төр, эдийн засгийн өөрчлөлтийн нөлөөгөөр дэлхийн түүхийг сонирхон судлах явдалд эрс өөрчлөлт гарч 1979 онд Хятадын НШУА-ийн дор Дэлхийн түүх судлах хүрээлэн байгуулагдан дэлхийн түүхээр дагнасан сэтгүүл гаргах болжээ. Үүний сацуу 1980-аад оны туршид хятадын дээд боловсролын тогтолцоонд явагдсан интернациональжуулалтын үр дүнд барууны, тэр дундаа АНУ-д боловсрол эзэмшсэн бүхэл бүтэн бүлэг түүхчид төрөн гарч 1990 он гарахад хятадын их, дээд болон ерөнхий боловсролын сургуулиудад дэлхийн түүх судлах, сургах явдал хүчтэй байр суурьтай болсон байна. Энэ үед хятадын бараг бүх түүхийн тэнхимүүд дэлхийн түүхийг ямар нэг хэмжээгээр судлах бүтэцтэй, хятадын түүхчдийн 40 орчим хувь нь дэлхийн түүх дагнан судалж байжээ. Гэхдээ энэ үед дэлхийн түүх гэдэгт ерөнхийдөө хятадын бус бүх түүхийг хамруулан ойлгох нь хэвээр байсан тул гадаад орны ямар нэг түүх судалдаг бүх судлаачид дэлхийн түүхч гэсэн категорт багтаж байсан онцлогтой байв.

Харин сүүлийн үед БНХАУ-д дэлхийг түүхийг ойлгох ойлголт нэлээд өөрчлөгдөн Хятад болон дэлхийн бусад бүс нутгуудын хооронд түүхэнд явагдаж байсан янз бүрийн түвшний харилцаа холбоо, хамаарлыг чухалчлан судлах нь улам ихэссэн байна. Мөн энэ хандлага ерөнхий боловсролын түүхийн сургалтанд ч нөлөөлж 2000 онд хятадын ерөнхий боловсролын түүхийн цөм хөтөлбөр шинэчлэгдэх үед бусад иргэншил, соёлыг хүндэтгэн үзэх, түүхийг дан ганц европ төвт юм уу хятад төвт үзлээр хандахгүй нэгдмэл байдлаар ухааран ойлгох гэсэн шинэ стандартууд нэмэгдсэн байна. Саксенмаейрын дүгнэснээр, эдүгээ хятадын түүхчид евроцентризмийг даван туулахын тулд дэлхийн түүх гэхээсээ илүү өнөөгийн Хятадын дэлхийд эзлэх байр суурийг тодотгох, тайлбарлах боломжийг олгосон глобаль түүх судлан шинжилж эхэлжээ.²² Дашрамд дурдахад 2005 оны байдлаар, хятадын их сургуулиудад дэлхийн түүх дагнан судалдаг 37 хүрээлэн байж, тэдгээрийн боловсон хүчний 42 хувь нь харь улсуудад, ялангуяа барууны орнуудад ямар нэг хэмжээгээр мэргэжил дээшлүүлсэн байв. 2008 онд Хятад, Япон, Энэтхэг, Өмнөд Солонгос зэрэг Азийн хэд хэдэн орны эрдэмтэд хамтран Азийн Дэлхийн Түүхчдийн Холбоог (Asian Association of World Historians) байгуулан ажиллаж байна.

2. Дэлхийн түүх ба үндэстний үзлийг даван туулахуй

²¹ Girard, Brian and Harris, Lauren McArthur. “Global and World History Education.” Scott Alan Metzger and Lauren McArthur Harris (eds.) *The Wiley International Handbook of History Teaching and Learning*. New York: Wiley-Blackwell, 2018, 254.

²² Sachsenmaier, Dominic. *Global Perspectives on Global History: Theories and Approaches in a Connected World*. Cambridge: Cambridge University Press, 2011, 172-231.

Түүхийг глобаль перспективээр харж судалснаар манай улсын түүхийн судалгаанд “чөдөр тушаа” болсоор ирсэн европ төвт үзлээс ангижрах боломжийг ямар нэг хэмжээгээр олох боломжтой юм гэдгийг илтгэлийн өмнөх хэсэгт харуулахыг оролдлоо. Харин энэ хэсэгт түүхэнд глобаль перспективээр хандах нь үндэстний түүхийг үгүйсгэнэ гэсэн үг огт биш бөгөөд харин ч дэлхийн/глобаль түүхийг судлах, сургалтанд нэвтрүүлэх нь аливаа нэг үндэстэн өөрийгөө ухааран ойлгох, үндэстний ижилслээ тодорхойлон тайлбарлах, үндэстнийхээ түүхийг илүү итгэлтэй бөгөөд үнэмшилтэй танин мэдэхэд тусалдаг болохыг онцлон тэмдэглэх гэсэн юм. Энэ нь эх орны түүхийг дан ганц түүний хил хязгаараар тусгаарлаж бичиж байсан туршлагаас татгалзаж, Монголын түүхийг бүс нутаг, тив, дэлхийн түүхийн янз бүрийн талбар, контекстэд авч үзнэ гэсэн үг юм. Бид хэдий чинээ эх түүхийн судалгааг өргөн цар хүрээгээр харж судална, төдий чинээгээр түүхийн үйл явц, үйл явдлуудын утга учрыг тодруулж чадна.

Өнөөгийн Монголын түүхийн шинжлэх ухаанд нэн шаардлагатай буй энэ аргазүйн хандлага зөвхөн эрдэм шинжилгээнд ч хамаатай бус, мөн түүхийн аль ч түвшний боловсрол, сургалтанд хамаатай. Дэлхийн түүх суурьтай сургалт явуулж дэлхийн түүхийн судалгаа хийх чадвартай боловсон хүчин бэлтгэн гаргана гэдэг нь харийн түүх, соёлыг шүтэн бишрэхийн хэрээр эх түүхээ доршоон муулах юм уу үл ойшоох хандлагатай ирээдүйн түүхчдийг бэлтгэн гаргана гэсэн үг бүр ч биш. Суралцагчид, оюутнуудад тэдний өсөж хүмүүжсэн нийгмийн өнгөрсөн аливаа үйл явдлын утга учрыг аль болох олон талаас, үзэл бодлын өргөн цар хүрээтэй тайлбарлах тусам тэдний эх түүхээ сонирхон судлах, шинжлэх ухаанчаар танин мэдэх, ойлгон ухаарах гэсэн хүсэл эрмэлзэл нэмэгддэг болохыг багш бид нар сайн мэдэх билээ. Дэлхийн түүхийг сургалтанд илүү ихээр нэвтрүүлснээр өнөөгийн дээд боловсролын сургалтанд түүх, түүхийн шинжлэх ухааныг голчлон эх түүхийн, үндэстний хил хязгаарын хязгаарлагдмал цар хүрээ, жишээнд авч үзэж буй байдлыг “тэнцвэржүүлэх” ач холбогдолтой.

Нөгөө талаар, дэлхийн түүхийн боловсролыг сургалтанд нэвтрүүлэх нь суралцагчдад зөвхөн үндэстний адилслага зөв ухааран ойлгоход ч бус, мөн удам угсаа, гэр бүл, шашин шүтлэг, хүйс зэрэг өнгөрсөн түүх болон өнөө үед оршин буй нийгэм болон соёлын болон иргэний адилслага зөв тодорхойлох, танин мэдэх, төлөвшүүлэхэд нь тусална. Гагцхүү мэргэжлийн сургалт явуулж буй тэнхимүүд сургалтын хөтөлбөртөө дэлхийн түүхийн агуулгыг нэмэгдүүлэн боловсруулахдаа ийм сургалтын үр дүнд оюутнууд өөрсдийн адилслага зөв танин мэдэж ухаарах хандлагатай болсон байхыг харгалзан үзэж боловсруулах хэрэгтэй санагдана. Үүний зэрэгцээ эх түүхийн аливаа үйл явдал, үйл явцад холбогдох асуудлуудыг илүү том асуудал, өргөн цар хүрээнд авч үзэх нь оюутнуудад

1. Тэрхүү түүхэн асуудлуудыг газарзүй, хронологийн олон цаг үед, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын өөр өөр орчин, контекстэд болж өнгөрсөн адил төстэй асуудлуудтай харьцуулах (*comparing*), уялдаа холбоог нь олох (*connecting*), шинэ санаа дэвшүүлэн илэрхийлэх, тайлбарлах (*conceptualizing*), түүхэн нөхцөл байдалд нь ухааран ойлгох (*contextualizing*) шаардлагыг бий болгоно.²³
2. Энэ нь эргээд өөрсдийнх нь судлахыг хүссэн эх түүхийн асуудлыг илүү ихээр танин мэдэх бололцоог нэмэгдүүлнэ.
3. Үүний зэрэгцээ үндэстний болон дэлхийн түүхэн үйл явдал, үйл явц, асуудлуудыг судалгааны өөр үзэл санаа, хандлагаар авч үзэх магадлалыг дээшлүүлэх ба тэр хэрээр судалгааны шинэ аргазүй, аргачлал, онолд суралцах хэрэгцээ шаардлагыг нь нэмэгдүүлнэ.

²³ Oltsein, Diego. *Thinking History Globally*. New York: Palgrave MacMillan 2015.

Жишээ нь, дэлхийн түүхийн судалгаанд Анналийн дэг сургуулийн *longue durée*, тоон судалгааны аргазүй өргөн ашиглагдаж байна.

4. Мөн олон янзын сурвалж хэрэглэгдэхүүнүүдийг ашиглах, судалгаа, сургалтын хэлнүүдийн илүү өргөн мэдлэг, чадвар олох сэдлийг ч буй болгоно.

Тиймээс МУИС-ийн 2014 оны сургалтын шинэчлэл хийх үед Түүхийн тэнхимийн хөтөлбөрийн дэд хорооноос сургалтын хөтөлбөртөө өөрчлөлт оруулж дэлхийн түүхийн хичээлүүдийн тоо, багц цаг, агуулгыг нэмэгдүүлээд байна. Жишээ нь, МУИС-ийн Хүмүүнлэгийн ухааны мэргэжлийн суурийн хичээлийн хөтөлбөрт Түүхийн тэнхимээс урьд өмнө боловсруулагдаж байгаагүй “Дэлхийн түүх” хичээлийг санал болгосон ба энэ хичээл нь дотроо бүс нутгаар дөрвөн хэсэгт, үүнд Баруун Европ, Орос болон Зүүн Европ, Зүүн Ази, Ойрхи болон Дундад Дорнодын түүх гэж задран тус тусдаа өөр багш дангаар заахаар төлөвлөгдсөн. Мөн мэргэжлийн түүхийн ангийн хөтөлбөрт “Социалист системийн түүх”, “Монголын тусгаар тогтнолын түүх ба их гүрнүүдийн бодлого”, “Зоос ба дэлхийн худалдааны түүх” гэх мэт хичээлүүдийг сонголтоор үзэх боломжтой болгосноос гадна урьд өмнө сургалтын төлөвлөгөөнд багтсаар ирсэн дэлхийн түүхийн хичээлүүдийн агуулгыг ч гэсэн улам өргөтгөсөн болно. Миний зааж буй “Дундад зууны түүх” хичээлийн хувьд гэхэд агуулга нь 2012 оноос өмнө заагдаж байсан агуулгаас хавьгүй өргөн болж боловсруулагдсан. Одоо оюутнууд энэ хичээлээр ойролцоогоор НТ 500-1500 оны хоорондох зөвхөн Баруун Европ, Зүүн Азийн түүх төдийгүй мөн Африк, Өмнөд болон Умард Америк, Энэтхэг, Зүүн-Өмнөд Ази, эцэст нь Ислам шашинт болон түрэгийн ард түмнүүдийн түүх судлаж байна. Дэлхийн түүхийн агуулгыг нэмэгдүүлсэн энэ өөрчлөлтийг одоогоор зөвхөн бакалаврын түвшинд хийх боломжтой буй бөгөөд ирээдүйд төгсөлтийн дараах сургалтыг ч адил маягаар сайжруулах алсын зорилготой бодлогыг манай улсын түүхийн ууган тэнхим баримталж байна. Цаашдаа дэлхийн түүхийн агуулгатай курс хичээлүүдийн тоо, агуулга болон боловсон хүчнийг бодлогоор нэмэгдүүлвэл зохино.

3. Дэлхийн түүх ба иргэний даяарших чадварыг төлөвшүүлэхүй

Урьд өмнө өөр хоорондоо дайсагналцсан, талцсан, хуваагдсан, ойлголцолгүй, харилцаагүй, нэгдмэл бус байсан дэлхийн олон бүс нутаг, улс орон, газар нутгийн ялгаатай нийгэм, эдийн засаг, соёл эдүгээ даяаршин буй өнөө цаг үед дэлхийн түүхийн боловсролын ач холбогдол улам их болж байна. Бусад ард түмэн, соёл, нийгэм, эдийн засгийн өөр, ялгаатай байх тал, чанаруудыг үнэн зөв ухааран ойлгохгүйгээр үр дүнтэй харилцан холбогдох, хамтран ажиллах боломжгүй юм. Улс үндэстний дээд боловсролын аливаа бодлого ч өнөөгийн даяаршлын эрин цаг үетэй нийцэн зохицох ёстой. Тиймээс МУИС-ийн Түүхийн тэнхимийн хувьд сургалтын хөтөлбөрөө энэ шаардлагад нийцүүлэн боловсруулахыг хичээж байна. Тус тэнхим 2014 онд шинэчилсэн сургалтын хөтөлбөртөө “даяарчлагдан буй өнөө үед... дэлхийн жишигт ойртсон.. иргэнийг бэлдэх зорилготой” хэмээн тодорхойлсон:

Даяарчлагдан буй өнөө үед аливаа хувь хүн, улс үндэстэн, бүс нутгийн тусгаар хийгээд хамтран орших, хөгжин дэвшихэд түүхийн нарийн тодорхой мэдлэг олж авах, нийгэм-соёлын бүхий л хүрээнд түүхийн ухааны өргөн цар хүрээтэй судалгаа хийх явдал улам их шаардагдаж, нэн чухал ач холбогдолтойд тооцогдох болжээ. Монгол улсын хэмжээнд түүхийн судалгаа, сургалтын цогц үйл ажиллагаа явуулдаг хамгийн том төв болох Түүхийн тэнхим нь тус оронд явагдаж буй дээд боловсролын шинэчлэлийн бодлогын үйл ажиллагааны хүрээнд суралцагчдад дэлхийн жишигт ойртсон, өргөн хүрээтэй суурь мэдлэг олгох, онол-ур чадварыг хослуулан эзэмшүүлэх, бие даасан,

шүүмжлэлт, бүтээлч сэтгэлгээтэй иргэнийг бэлдэх зорилготойгоор түүхийн ухааны бакалаврын сургалтын хөтөлбөрөө шинэчлэн боловсруулаад байна.²⁴

Түүхийн сургалтад дэлхийн түүх суурьтай болгон өөрчлөх шаардлага ч дээрх зорилготой нийцэх нь гарцаагүй. Ерөөс дээд боловсрол дахь түүхийн сургалтанд дэлхийн түүхийн агуулгыг өсгөх нь сургалтын олон талын ач холбогдолтой. Оюутнууд дэлхийн түүхийн хичээлүүдээр дамжуулж үндэстний болон олон улсын геополитик, улс төрийн үйл явцын бүрэн ойлголт мэдлэг, хувь хүний болон соёлын түвшинд бусадтай чөлөөтэй, нээлттэй харилцах чадвар, мөн олон улсад өрсөлдөхүйц иргэний боловсрол, чадвартай болох боломжтой. Ирээдүйд глобаль орчин, олон улсын байгууллага, үндэстэн дамнасан соёлын нөхцөл байдалд ажиллаж, амьдрахыг хүсэж буй залуучуудад дэлхийн түүхийн агуулгатай хичээлүүд нэн шаардлагатай. Иргэний глобаль мэдлэг боловсрол, өрсөлдөх чадвар, ёс зүй (global citizenship competency) дан ганц оюутнуудад ч бус, мөн төр, олон нийтийн байгууллагад ч зайлшгүй хэрэгтэй болж байна. Олон улсад хийсэн зарим судалгааны үр дүнд сургалтын хөтөлбөрт дэлхийн түүхийн агуулгыг нэмэгдүүлэх нь дээрх зорилгод хүрэхэд сайн үр дүн үзүүлж байгааг онцлон тэмдэглэжээ.²⁵ Энэ тухай бичсэн нэгэн өгүүлэлд дурдсанаар, “Дэлхийн түүхийг анхаарал болгоомжтой, ухаалгаар боловсруулан таниулах нь оюутан суралцагчдад болон багш сурган хүмүүжүүлэгчдэд соёл, иргэншил, онол, эрдэм шинжилгээ, цаг хугацаа, газарзүйн хил, хязгаарыг даван туулахад нь тусалдаг... Сайтар боловсруулсан дэлхийн түүхийн боловсрол өргөн цар хүрээнд ухаарч ойлгох чадвартай, мэдлэг мэдээлэлтэй “глобаль иргэдэд” амьдрал хийгээд суралцах үйл ажиллагаандаа уян хатан, шүүмжлэлт хандлагатай болон төлөвшихөд, мөн оршин буй нийгмийнхээ болон дэлхий ертөнцийг улам олон ургальч, цогц байдлаар ухааран ойлгоход нь нэмэр болдог”²⁶. Тиймээс олон улсын хэд хэдэн боловсролын байгууллагуудаас улс орнуудын ерөнхий болон дээд боловсролд глобаль боловсрол олгохын чухлыг онцолж²⁷ дэлхий болон олон улсын түүх заах сургалтын стандартыг батлан гаргасан, тэдгээрийг зарим орнууд шууд өөрийн улсын түүхийн боловсролын стандарт болгон (жишээ нь, Швед) хэрэгжүүлсэн байх ажээ.

Монгол улсын их сургуулиудын түүхийн тэнхимүүд үндэсний чиг баримжаатай түүхийн сургалт, судалгаанаас бүс нутаг, глобаль чиг баримжаатай болон өөрчлөгдөхөд улс төр, нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйл шалтгаалах ч хамгийн гол нь түүнд ажиллаж буй багш, судлаачдын хүсэл, сонирхол, санаачлага, мэдлэг чадвараас хамгийн их шалтгаантай байх нь гарцаагүй. Хэрвээ тэнхимийн боловсон хүчнүүдэд өөрийн хүсэл зориг байх бол түүнийг гүйцэлдүүлэх хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, үзэл баримтлал, бодлого, үйл ажиллагаагаа уялдуулан тодорхойлох, тийнхүү тодорхойлсноо хэрэгжүүлэхийн төлөө тууштай ажиллах нь нэн чухал. Ингэхийн тулд тэнхимүүд:

²⁴ МУИС-ийн Түүхийн тэнхимийн сургалтын төлөвлөгөө, 2014.

²⁵ Girard, Brian and Harris, Lauren McArthur. “Global and World History Education.” Scott Alan Metzger and Lauren McArthur Harris (eds.) *The Wiley International Handbook of History Teaching and Learning*. New York: Wiley-Blackwell, 2018, 260;

²⁶ “A careful and considered conceptualization and presentation of world history can help students and educators transcend all sorts of boundaries and borders – cultural, “civilizational”, theoretical, disciplinary, temporal, and geographical... Good world history... would thus contribute to the nurturing of more inclusive, emphatic, and informed “global citizens” who would have a flexible and critical approach to life and learning and more multicentric, complex, and cosmopolitan understandings of their own societies and the world at large.” Carey A. Watt. “World History, Liberal Arts, and Global Citizenship.” *Journal of General Education* 61/3, 2012, 213-214.

²⁷ Organization for Economic Cooperation and Development. *Education at a glance*. 2018.

www.oecd.org/education/education-at-a-glance/ (хамгийн сүүлд 2019 оны I сарын 17); UNESCO. *UNESCO Guidelines on intercultural education*. 2006. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000147878> (хамгийн сүүлд 2019 оны I сарын 17).

- сургалтын хөтөлбөрөө шинэчлэн боловсруулах,
- судалгааны төсөл, ажил хийхдээ эх орны түүхэнд бүс нутаг, глобаль түүхийн перспективийг аль болох тусгах,
- олон улсын сургалтын арга, туршлагыг нэвтрүүлэх,
- олон улсын сургалтын болон эрдмийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх,
- тусгай семинар, зуны сургалт, тусгай сэдвийн хурлуудыг олон улсын адил зорилготой тэнхим, эрдэмтэн багш нартай хамтран зохион байгуулах,
- багш, суралцагчдын олон улсын эрдмийн солилцоонд хамрагдах, нэгдэх явдлыг дэмжиж идэвхижүүлэх,
- олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн судлаач, багш, боловсон хүчнийг урьж хичээл, семинар хийлгэх,
- хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- олон улсын оюутнуудын элсэлтийн тоог нэмэгдүүлэх,
- англи хэлийг сургалт, судалгаа, харилцаандаа хэрэглэх

зэрэг янз бүрийн “интернациональжуулах бодлого”-ыг уламжлал, нөхцөл байдалтайгаа тохируулан хэрэгжүүлж болно. Мөн эцэст нь, зохион байгуулагдаж буй энэхүү семинарын гол сэдвүүдийн нэг болох сурах бичгийг тохируулан өөрчилж, дэлхийн түүх суурьтай бичин хэвлэж ч болно.

4. Сурах бичгийн шинэчлэл ба глобаль перспективээр харах үзэл баримтлал

Сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаанд дэлхийн түүхийн боловсролыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор зайлшгүй тавигдах асуудал бол сурах бичгийн асуудал юм. Хэдийгээр хөгжингүй улс орнуудын дэлхийн түүхийн сурах бичгүүдэд ч гэсэн тухайн үндэстэн улсын геополитик, эдийн засгийн ашиг сонирхол, соёлын асуудлаас шалтгаалан түүхийн зарим цаг үе, орон зай, асуудал сэдэвт үндэстний үзэл юм уу европ төвт үзлийн үүднээс гуйвуулсан, бүрхэгдүүлсэн, орхигдуулсан тал, хандлага ажиглагддаг ч гэсэн үндэстний болон дэлхийн түүхийн сурах бичгүүдийг глобаль перспективээр харж бичих явдлыг онцгой чухал асуудалд тооцон үздэг байна.

МУИС-ийн Түүхийн тэнхим 1990 оны сүүл үе, 2000-аад оны эхэн үеэс сурах бичгээр дамжуулан сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаагаа шинэчлэн өөрчлөхийг эрмэлзсээр ирсэн. Энэ зорилгоор тэнхимийн багш нар *Монгол улсын түүх* (1999)²⁸, *Дэлхий дахины түүх* (2002)²⁹, *Дорно дахины дундад зууны түүхийн унших бичиг* (2011)³⁰, *Дундад зууны түүх* (2012)³¹, *Дэлхийн түүх* (2012)³² зэрэг сурах бичиг, сургалтын материалуудыг хэвлэн гаргажээ. Хамгийн сүүлийн байдлаар бид өнгөрсөн жил *Монгол улсын түүх* гэсэн сурах бичиг хэвлүүллээ. Энэ шинэ сурах бичиг нь дээд боловсрол шинэчлэгдэж буй өнөө цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилсэн сурах бичиг болж байгаагаараа онцлогтой. Тиймээс редактор болон зохиогчид урьд өмнөх түүхийн сурах бичгүүдийн ололттой болон шүүмжлэлтэй, сул талуудыг тодорхойлохыг оролдож “...түүхийн сурах бичгийг оюутанд биш, харин багш нар өөрсдөдөө зориулан зохиосон юм шиг сэтгэгдэл төрүүлэхүйц байдаг нь нууц биш юм. Сурах бичигт дидактикийн янз бүрийн шийдлээр хомс, өнгө үзэмж тааруу, үг үсгийн алдаа мадаг ихтэй, өөр хоорондоо логик зөрчил бүхий бичвэрүүдтэй, ойлгомжгүй, нуршуу үг хэллэгтэй, аливаа зураг, зураглал, бичвэрийн эх сурвалж нь тодорхойгүй,

²⁸ *Монгол улсын түүх*. Ред. Ж.Болдбаатар нар. Улаанбаатар: Соёмбо 2010.

²⁹ Болдбаатар, Ж., Баасанжав, З. *Дэлхий дахины түүх*. 2 боть. Улаанбаатар 2002.

³⁰ Гонгоржав, У. *Дорно дахины дундад зууны түүхийн унших бичиг*, Улаанбаатар: Өнгөт хэвлэл 2011.

³¹ Гонгоржав, У. *Дундад зууны түүх*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр 2012.

³² Баасанжав, З., Урангуа, Ж., Энхцэцэг, Д., Мөнхцаг, Ш. *Дэлхийн түүх*. Улаанбаатар: Соёмбо 2012.

олон ургальч үзэл бодол, байр суурийг харуулаагүй, зарим түүхэн үйл явдал, асуудлыг зориуд орхигдуулсан, өнөө цаг үетэй холбон тайлбарлаагүй зэрэг дутагдлууд байсаар л байна”³³ гэж үзэж хандлагын хувьд:

1. Олон хэв маягийн (multi-modal) бичвэр бүхий дидактик шийдлүүдтэй,
2. Суралцагчдын сурах үйл ажиллагааны явцад нь тусалж, дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ сурах орчинтой нь нягт уялдсан,
3. Сурах бичгийг бүтээж буй зохиогч нарын гэхээсээ илүү суралцагчдын хүртэхүй, хэрэглээг чухалчилсан,

нэг үгээр хэлэхэд оюутны “сайн анд нөхөр” болж чадах түүхийн сурах бичиг зохиохыг зорьсон юм. Өөрөөр хэлбэл, шинэ сурах бичгээр дамжуулан МУИС-ийн Түүхийн тэнхим Монголын дээд боловсролын цаашдын шинэчлэлд идэвхитэй оролцох, мэргэжлийн болон нийтийн түүхийн боловсролыг сайжруулахыг оролдсон билээ.

Энэ сурах бичгийг бичих, хэвлэн гаргах үйл явц амар байгаагүй. Юуны түрүүнд дэлхийн, ялангуяа СИН-ийн орнуудын их, дээд сургуулиудын сургалтанд ашиглагддаг түүхийн сурах бичгийн стандарт шаардлага, ололт амжилт, туршлага ямар байдаг вэ гэсэн асуулт тавигдсан. Дараа нь тэдгээр дэлхийн стандарт, туршлагын чухам аль нь Монголын, нэн ялангуяа тус тэнхимийн нөхцөл, байдалд тохирох вэ гэсэн асуудалтай тулгарсан. Эцэст нь, бид өөрсдөөсөө олон улсын ололт, туршлагыг нэвтрүүлэхэд үнэхээр бэлэн байна уу гэж асуухад ч хүрч байлаа. Тус сурах бичиг хэвлэгдсэн хойно сургамж болохоор туршлага ч хуримтлууллаа.

Ийм сурах бичиг бичихийн тулд олон улсын сурах бичигт түгээмэл ажиглагдаж буй үзэл баримтлалуудыг тодорхойлж, тэдгээрээс Монголын нөхцөлд нэн шаардлагатай бөгөөд нийцсэн гэж үзсэн гурван зарчим тодорхойлсны дотор хамгийн чухал нь “өнгөрсөн түүхийг глобаль перспективээр харах” зарчим баримтлахаар шийдсэн явдал байв. Сурах бичигт глобаль перспективээр өнгөрсөн түүхийг харж бичих зарчмыг баримталснаар дээр дурдсанчилан, оюутнууд евроцентрист үзлээс ангижрах, үндэстний түүхийг илүү өргөн цар хүрээнд авч үзэх, өнөө үеийн даяаршлын эрин үеийн хэрэгцээ шаардлагатай нийцэх ач холбогдолтой. Товчхондоо, эх орны түүхийг дан ганц хил хязгаараар нь тусгаарлаж бичдэг туршлагаас татгалзаж, Монголын түүхийг бүс нутгийн, тивийн, дэлхийн түүхийн эрт үеэс өнөө үе хүртэлх янз бүрийн контекстэд авч үзэж бичнэ гэсэн үг.

Жишээ нь, дээрх үзэл баримтлалыг хэрэгжүүлэхдээ “бүтэц”-ийн аргаар бичиж болно. Бүтцийн аргыг хэрэглэхэд дээрээс доош, доороос дээш чигтэй гэсэн хоёр янзаар бичиж болмоор шиг санагдана. Дээрээс доош чигтэй арга нь дэлхийн түүхэн цаг үеүүдийг тодорхойлж байсан улс төр-нийгэм-эдийн засаг-соёлын бие даасан төвүүдийг эхэлж тодорхойлоод, тэдгээр нь өөр хоорондоо хэрхэн харилцаж байсан, тэдгээр харилцаанд Монгол орон, Монгол улсын хувьд ямар байдлаар оролцож байсныг тодорхойлж бичих явдал. Эсвэл үүний эсрэгээр доороос дээш чигтэй болгож Монгол нь орон нутгийн хувьд төвлөрсөн газар нутаг, төвлөрсөн хүчинд хэрхэн хуваагдаж байсан, тэдгээр нь хэрхэн бүрэлдэж бий болсон, эргээд тэдгээр төвлөрөл нь түүнээс том төвлөрөл, газар орон, бүс нутаг, хүчинтэй хэрхэн холбогдон хэрхэн илүү том сүлжээ, харилцаа, бүтэц үүсгэсэн, түүнд монгол ямар үүрэг, үйл ажиллагаатай оролцож байсныг тодорхойлон бичиж болно.

³³ Монгол улсын түүх (2017) сурах бичгийг бичсэн туршлагаас хуваалцсан хэлэлцүүлгийн дэлгэрэнгүйг Чинзориг, Б. “МУИС-ийн түүхийн сурах бичиг бичсэн туршлагаас”. *Түүхийн сургалтын шинэчлэл: Явц, үр дүн, тулгамдсан асуудал*. Улаанбаатар: Удам соёл, 2017, 68-90-ээс үзнэ үү.

Чухамдаа Монголын өнгөрсөн түүхийг ингэж глобаль перспективээр харснаар *нэгдүгээрт*, түүхэн цаг үеүүдэд монголыг дэлхийн бусад улс орон, ард түмнүүд, байгуулалуудтай ямар харилцаа, холбоотой байсан, тэрхүү харилцаа холбоо явагдах түүхэн нөхцөл байдал, сүлжээ ямар байдалтай байсан, глобаль үйл явдлууд монголд хэрхэн нөлөөлсөн, монгол өөрөө глобаль үйл явдлуудад яаж нөлөөлж байсан тухай оюутнуудад ойлгуулах ач холбогдолтой. *Хоёрдугаарт*, чухам ингэж бичиж байж бид дэлхийн түүхэн нөхцөл байдалд өнөөгийн монгол ямар байр суурьтай оролцож байгаа, ирээдүйд монгол улс ямар байдалтай оролцох, ямар үүрэг гүйцэтгэх, ямар байр суурь баримтлах ёстой тэрхүү утга учирьг түүхийн судалгаанд үндэслэн томъёолох, тайлбарлах чадварыг оюутнуудад олгож чадна.

Сурах бичгийн үзэл баримтлалыг тодорхойлон бичих явдал голдуу түүхч, судлаачдын хэрэг, мөн түүний дидактикийн шийдлүүдийг сонгох нь багш нарын хэрэг, гэтэл сурах бичгийн текстийг бүрэн илэрхийлэхүйц хэвлэлийн загвар, бүтцийг тодорхойлох нь зөвхөн тэд төдийгүй мөн хэвлэгч, дизайнер, спонсор гээд өөр олон мэргэжилтэн, хүчин зүйлсээс шалтгаалж байдаг. АНУ-ын их, дээд сургуулийн бакалаврын түвшний гол, тэргүүлэх түүхийн сурах бичгүүдийг үзэхэд сурах бичигт үндсэн текстээс гадна олон хэв маягийн модуль бүхий дидактикийн шийдлүүд, сурах бичгийн агуулгыг оюутнууд хэрхэн эзэмшсэнийг шалгах боломж бүхий сорилын дэвтэр, анхдагч эх сурвалжийн эмхэтгэл, мөн интерактив компакт диск, тэр бүү хэл тусгай мэдээлэл агуулсан вэбсайт дагалдуулсан нь түгээмэл харагдана (Хүснэгт 1). Олон улсын сурах бичгийн бүтэц, дизайнд тавигдаж байдаг шаардлага, жишгүүдийг монгол улсын их, дээд сургуулиуд өөрийн нөхцөл бололцоонд тулгуурлан аль болох авч хэрэгжүүлэх, тийнхүү нэг сурах бичиг нөгөөг бичиж хэвлэх бүртээ улам сайжруулж байх нь нэн чухал.

Хүснэгт 1. МУИС-ийн Түүхийн тэнхимээс гаргасан сурах бичгүүдийн бүтцийн харьцуулал

АНУ дахь түүхийн сурах бичгүүдийн бүтцийн элементүүд	Монгол улсын түүх, 1999 сурах бичгийн бүтэц	Монгол улсын түүх, 2017 сурах бичгийн бүтэц	Дэлхийн түүх, 2020 сурах бичиг
Бүлгийн агуулгын хураангуй	●	●	●
Бүлгийн задаргааны хураангуй		●	●
Газрын зураг		●	●
Зураг, зураглал	●	●	●
Бүдүүвч	●	●	●
Хүснэгт		●	●
Булан		●	●
Он дарааллын хүснэгт		●	●
Нэр томъёоны тайлбар	●		●
Дэлгэрүүлж унших материалын жагсаалт		●	●
Зохиогчийн эрхийн жагсаалт		●	●
Нэрийн хэлхээс		●	●
Суралцагчийн мэдлэг, чадварыг шалгах тест	●		●
Сурвалжийн эмхэтгэл			●
Интерактив мэдээллийн сан CD-ROM			
Вэбсайт			

МУИС-ийн Түүхийн тэнхимийн *Монгол улсын түүх* (1999) сурах бичгийн бүлэг сэдэв бүрт суралцагчдын олж авах ёстой мэдлэгийг шалгаж үнэлэх сорил зохиогдсон бол *Монгол улсын түүх*

(2017) сурах бичигт ийм сорил агуулагдаагүй хэвлэгдсэн (Хүснэгт 1). Эдгээр сурах бичгүүдэд анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудын эмхэтгэл дэвтэр зохиогдоогүй. Редактор, зохиогчдын зүгээс эдгээр дутагдлуудыг нөхөн засч сорилын эмхэтгэл, эх сурвалжийн эмхэтгэлийг зохих ёсоор үйлдэн дараа дараагийн эх түүхийн болон дэлхийн түүхийн сурах бичгийн хэвлэлүүдэд дагалдуулан үйлдэх хэрэгтэй. Үүний сацуу, *Монгол улсын түүх* (2017) сурах бичигт олон улсын сурах бичигт багтдаг дидактикийн олон хэв маяг бүхий (multi-modality) янз бүрийн шийдэл-элементүүдийг аль болох тусгахыг оролдсон. Газрын зураг, он дарааллын хүснэгт, булан, нэр томъёоны тайлбар, дэлгэрүүлж унших материалын жагсаалт, нэрийн хэлхээс гэх мэт дидактик шийдэл-элементүүдийг оруулснаар олон зохиогч нарын ялгаатай үзэл санааг өөр хооронд нь холбох юм уу эсвэл тэдний ямар нэгэн хэмжээгээр хайхарч хөндөөгүй/хөнддөггүй байсан, эсвэл бага анхаарал хандуулсан/хандуулдаг байсан асуудлуудыг сурах бичгийн төвд оруулах, түүхийн шинжлэх ухааны өөрийнх нь хөгжил дэвшил, судалгааны аргагүй, үзэл санааны олон талт байдал, өнгөрсөн, одоо үеийн залгамж чанар зэргийг суралцагчдад ойлгуулах, тэдний бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, суралцагчийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, түүх сонирхон судлах сэдлийг төрүүлэх зэргээр тэдний хэрэгцээ, шаардлагад аль болох ойртуулах зорилгоор хийсэн олон элементүүд зохиож оруулсан.

ЕБС-уудад л сурах бичиг чухал, харин их сургуулийн түвшинд сурах бичиг бичих шаардлагагүй, эсвэл олон улсад их дээд сургуулиуд сурах бичиг бичдэггүй гэж манай зарим судлаачид хэлэх нь байдаг. Гэтэл олон улсын дээд сургуулиуд сургалтын материалыг олон янзын агуулга, хэлбэрээр үйлдэн гаргаж байдаг, тэдгээр нь сурах бичиг (textbook), удиртгал (introduction), тусламж (companion/guide), гарын авлага (handbook), тайлбар болон нэвтэрхий толь бичиг (reference books – dictionary, encyclopedia) зэрэг сургалт, судалгаа хосолсон байдлаар гардаг, тэр бүү хэл ийм сургалт, судалгааны хэвлэл дагнан хэвлэдэг олон улсад нэр хүндтэй хэвлэлийн байгууллагууд бишгүй байдаг. Харин 1990-ээд онд нийгэм солигдсоноос хойш дээд боловсролын их дээд сургуулиуд түүхийн сургалтын материалыг олон улсын жишигт хөл нийлүүлж чаддаггүй юм аа гэхэд ойртуулан зохион хэвлэх хүсэл зориг болоод мэдлэг, чадвар дутаж байжээ гэж дүгнэвэл залуучууд бид бүхний дийлэнх нь санал нийлэх байх.

Эдүгээ их дээд сургуулийн мэргэжлийн тэнхимүүд сургалтын материалыг өнөөгийн шаардлагад нийцүүлэн зохиосноор дан ганц сургалт ч биш, мөн судалгаанд тулгарч буй олон бэрхшээлүүдийг даван туулах арга зам гэж үзэх нь зүйтэй. Өнөөгийн оюутан суралцагчид хэдхэн жилийн дараа ирээдүйн түүхч мэргэжилтнүүд болохгүй гэж үү?

Дүгнэлт

Монгол улсад явагдаж буй дээд боловсролын шинэчлэл нь үндэсний дээд боловсролын тогтолцоог “дэлхийн зэрэглэл бүхий” Америк, Англи тэргүүтэй “барууны” жишигт нийцүүлэн өөрчлөх гэсэн үйл явц юм. Энэ шинэчлэлийн хүрээнд МУИС-ийн Түүхийн тэнхим дан ганц *үндэстний түүхд* суурилсан сургалтын үйл ажиллагаа явуулахаа больж *дэлхийн түүх суурьтай* сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр зорих болсон юм.

Сургалтыг дэлхийн түүхийн агуулгатай болгон чиглүүлж өөрчлөх нь гурван чухал ач холбогдолтой: Нэгдүгээрт, энэ нь монголын түүхийн боловсрол, түүхийн судалгаанд буй евроцентрист үзлийг даван туулах боломжийг өгнө; Хоёрдугаарт, эх түүхийн судалгаа, сургалтыг бодитойгоор өргөтгөн тэлэх боломжийг олгоно; Гуравдугаарт, даяаршсан эрин цаг үе, нөхцөлд байдалд амьдрах, ажиллах, өрсөлдөх чадвартай боловсон хүчнийг бэлтгэхэд хувь нэмэр оруулж чадна.

Тиймээс дан ганц МУИС-ийн Түүхийн тэнхим төдийгүй, мөн түүхийн боловсрол олгогч бусад их дээд сургуулиудын тэнхмүүд цаашид олон улсын жишигт ойртсон сургалтын үйл ажиллагаа явуулахаар зорьж буй бол сургалтын хөтөлбөр дэх дэлхийн түүхийн агуулгыг улам эрчимтэй, тууштай нэмэгдүүлэх, судалгаа, сургалтын аль алиныг бүс нутаг, глобаль чиг баримжаатай болгон өөрчлөх шаардлагатай бөгөөд энэ нь Монголын түүхийн шинжлэх ухаанд тулгарч буй зарим асуудлуудыг ч шийдэхэд зохих ёсоор туслах нь дамжиггүй.

Хэдийгээр олон дутагдал, алдаа мадаг, сургамжтай, шүүмжлэлтэй зүйл буй ч сүүлийн жилүүдэд МУИС-ийн Түүхийн тэнхимээс эрхлэн хэвлэж буй сурах бичиг нь дээд боловсролын түүхийн сургалтыг олон улсын түвшинд ойртуулах гэсэн хүсэл эрмэлзлийн илэрхийлэл болж байгаа юм.

Ашигласан ном материал

Баасанжав, З., Урангуа, Ж., Энхцэцэг, Д., Мөнхцаг, Ш. *Дэлхийн түүх*. Улаанбаатар: Соёмбо 2012.

Болдбаатар, Ж., Баасанжав, З. *Дэлхий дахины түүх*. 2 боть. Улаанбаатар 2002.

Гонгоржав, У. *Дорно дахины дундад зууны түүхийн унших бичиг*. Улаанбаатар: Өнгөт хэвлэл 2011.

Гонгоржав, У. *Дундад зууны түүх (Их, дээд сургуулийн оюутан, магистрантууд, ЕБС-ийн багш нарт зориулсан сурах бичиг)*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр 2012.

Дэлгэржаргал, П. “Дээд боловсролын шинэтгэл ба мэргэжлийн түвшний түүхийн сургалтын тулгамсан асуудлууд”. *Эх түүхийн сургалт, боловсролын уламжлал, шинэчлэлийн асуудлууд (Илтгэлийн эмхэтгэл)*. Улаанбаатар: Адмон, 2012, 15-23.

Монгол улсын түүх (түүх, онол-арга зүйн асуудлууд). Ред. Ж.Болдбаатар нар. Улаанбаатар: Соёмбо, 2010.

Монгол улсын түүх. Ред. П.Дэлгэржаргал, Б.Чинзориг. Улаанбаатар: МУИС Пресс 2017.

Чинзориг, Б. “МУИС-ийн түүхийн сурах бичиг бичсэн туршлагаас”. *Түүхийн сургалтын шинэчлэл: Явц, үр дүн, тулгамдсан асуудал*. Эмх. О.Оюунжаргал, Д.Энхжаргал. Улаанбаатар: Удам соёл, 2017, 68-90.

Abu-Lughod, Janet L. *Before European Hegemony: The World System A.D. 1250-1350*. New York and Oxford: Oxford University Press 1989.

Allardyce, Gilbert. “Toward World History: American Historians and the Coming of the World History Course.” *Journal of World History* 1/1, 1990, 23-76.

Andrea, Alfred J. “On the Teaching of Global History.” *Historian* 53/1, 1990, 145-149.

Bain, Robert B. and Shreiner, Tamara L. “Issues and Options in Creating a National Assessment in World History.” *The History Teacher* 38/2, 2005, 241-271.

Bentley, Jerry H. “A New Forum for Global History.” *Journal of World History* 1/1, 1990, iii-v.

Bolgatz, Jane and Marino, Michael. “Incorporating More of the World into World History Textbooks: A Review of High School World History Texts.” *World History Connected* 11/2, 2014. <http://worldhistoryconnected.press.uillinois.edu/11.2/bolgatz.html> (хамгийн сүүлд 2019 оны I сарын 16)

Brooks, George E. “An Undergraduate World History Curriculum for the Twenty-First Century.” *Journal of World History* 2/1, 1990, 65-79.

Clarence-Smith, William Gervase et al. “Editorial.” *Journal of Global History* 1, 2006, 1-2.

- Dunn, E. Ross et al. (eds.) *The New World History: A Field Guide for Teachers and Researchers*. Oakland: University of California Press 2016.
- Girard, Brian and Harris, Lauren McArthur. "Global and World History Education." Metzger, Scott Alan and Harris, Lauren McArthur (eds.) *The Wiley International Handbook of History Teaching and Learning*. New York: Wiley-Blackwell, 2018, 253-279.
- Manning, Patrick. *Navigating World History: Historians Create A Global Past*. New York: Palgrave Macmillan 2003.
- Mazlish, Bruce. "Comparing Global History to World History." *Journal of Interdisciplinary History* 28/3, 1998, 385-395.
- McNeill, William H. *The Rise of the West: A History of the Human Community*. Chicago and London: University of Chicago Press 1963.
- McNeill, William H. "The Changing Shape of World History." *History and Theory* 34/2, 1995, 8-26.
- Oltsein, Diego. *Thinking History Globally*. New York: Palgrave MacMillan 2015.
- Organization for Economic Cooperation and Development. *Education at a glance*. 2018. www.oecd.org/education/education-at-a-glance/ (хамгийн сүүлд 2019 оны I сарын 17)
- Repoussi, M., Tutiaux-Guillon, N. "New Trends in History Textbook Research: Issues and Methodologies towards a School Historiography." *Journal of Educational Media, Memory, and Society* 2/1, 2010, 154-70.
- Sachsenmaier, Dominic. *Global Perspectives on Global History: Theories and Approaches in a Connected World*. Cambridge: Cambridge University Press, 2011, 172-231.
- Schissler, Hanna and Soysal, Yasemin Nuhoglu (eds.) *The Nation, Europe and the World: Textbooks and Curricula in Transition*. New York and Oxford: Berghahn Books 2005.
- UNESCO. *UNESCO Guidelines on intercultural education*. 2006. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000147878> (хамгийн сүүлд 2019 оны I сарын 17).
- Wallerstein, Immanuel. *The Modern World System II: Mercantilism and the Consolidation of the European World Economy, 1600-1750*. New York et al: Academic Press 1980.
- Watt, Carey A. "World History, Liberal Arts, and Global Citizenship." *Journal of General Education* 61/3, 2012, 211-228.